



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот


### Журам, жагсаалт, загвар батлах тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24.3, 32<sup>1</sup>.8-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт, “Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан мэдээлэл хариуцагчаас олгох лавлагаа, тодорхойлолтын загвар”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 259 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.




МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА  
ХОЛБООНЫ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Н.УЧРАЛ



Засгийн газрын 2023 оны 03 дугаар  
сарын 15.-ны өдрийн 100 дугаар  
тогтооолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ  
БАЙГУУЛЛАГААС ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар” гэх)-аас хүн, хуулийн этгээдийн гаргасан үйлчилгээ авах хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх, хүн, хуулийн этгээдэд хариу мэдэгдэх, төрөөс үзүүлж байгаа үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх, мэдээллээр хангахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар нь үйл ажиллагаанд даацах зарчмыг баримтална:

1.2.1. төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, нэг цонхоор хүртээмжтэй хүргэх;

1.2.2. үйлчилгээ үзүүлэх явцад олж мэдсэн хүний хувийн мэдээллийг бусдад задруулахгүй байх;

1.2.3. төрийн үйлчилгээний стандартыг ханган ажиллах;

1.2.4. хүн, хуулийн этгээдийн гаргасан үйлчилгээ авах хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх, хүн, хуулийн этгээдэд хариу мэдэгдэх ажиллагаа нэгдсэн тогтолцоо, удирдлагатай байх.

1.3. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас үзүүлэх үйлчилгээг дараах байдлаар ангилна:

1.3.1. лавлагaa, тодорхойлолт;

1.3.2. “нэг шатлалт үйлчилгээ” гэж үйлчилгээний хүсэлтийг хандсан цэгээс нь нэмэлт шат, дамжлагагүй шийдвэрлэн хариу өгөх боломжтой үйлчилгээг;

1.3.3. “олон шатлалт үйлчилгээ” гэж нийтийн мэдээллийн системээр дамжуулан үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч эрх бүхий байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлэх үйлчилгээг.

**Хоёр.Хүн, хуулийн этгээдийн гаргасан үйлчилгээ авах хүсэлтийг  
хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх**

2.1.Хүн, хуулийн этгээдийн үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч бүртгэхдээ иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах цаасан, цахим бичиг баримт, цахим гарын үсэг, эсхүл Засгийн газраас тогтоосон арга, хэрэгсэл бүхий танилт, нэвтрэлтийн системийг ашиглан таньж баталгаажуулсан байна.

2.2.Үйлчилгээ үзүүлэх ажилтан энэ журмын 1.3-т заасан үйлчилгээг хүлээн авсан талаар бүртгэл хөтөлнө.

2.3.Үйлчилгээ үзүүлэх ажилтан энэ журмын 1.3.1, 1.3.2-т заасан үйлчилгээг шийдвэрлэсэн тухай мэдээллийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр өгнө.

2.4.Үйлчилгээ үзүүлэх ажилтан энэ журмын 1.3.3-т заасан үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах баримт бичгийн бүрдлийг нягталж, шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд шилжүүлнэ.

2.5.Энэ журмын 1.3.3-т заасан үйлчилгээг шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд шилжүүлсэн, шийдвэрлэсэн, буцаасан, татгалзсан талаарх мэдээллийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр үйлчилгээ авах хүсэлт гаргасан хүн, хуулийн этгээдэд тухай бүр өгнө.

2.6.Энэ журмын 1.3.3-т заасан үйлчилгээг шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд шилжүүлсэн тохиолдолд хууль, журамд заасан хугацаанд шийдвэрлүүлэх талаар эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана.

2.7.Хүн, хуулийн этгээдийн гаргасан үйлчилгээ авах хүсэлтийг төрийн үйлчилгээний нэгдсэн систем, төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машин болон хувийн хэвшлийн киоск машин, мэдээлэл хариуцагчийн системээр дамжуулан хүлээн авч болно.

2.8.Хэрэв тухайн хэрэглэгчийн хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй, үйлчилгээний жагсаалтад багтаагүй бол тус үйлчилгээтэй холбоотой зөвлөмж өгч чиглүүлж болно.

**Гурав.Бусад**

3.1.Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас үзүүлэх үйлчилгээний жагсаалтад өөрчлөлт оруулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр саналаа цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.2.Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээг сайжруулах судалгааг хийж, дахин загварчлах, боловсронгуй болгох саналаа эрх бүхий байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.3.Төрийн үйлчилгээ үзүүлэх ажилтан үйл ажиллагаандаа холбогдох стандарт, журам, холбогдох бусад шийдвэр, үйлчилгээний чанарыг мөрдөж ажиллаж байгаа эсэхэд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар

хяналт тавьж, тайлангаа цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.4.Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг жилд нэгээс доoshгүй удаа хийж, судалгааны тайланг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.5.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем ашиглан үйлчилгээ үзүүлэх ажилтныг сургах, мэргэшүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлэх, холбогдох сургалтыг тогтмол зохион байгуулна.

3.6.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем ашиглан төлбөртэй үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд хүн, хуулийн этгээдийн төлбөр төлөх, төлбөрийг буцаах боломжийг бүрдүүлсэн байна.

3.7.Үйлчилгээ авах хүсэлтийг эрх бүхий байгууллагаас шийдвэрлэсэн тухай баримт бичгийг хүн, хуулийн этгээдэд хүргэх боломжийг бүрдүүлнэ.

3.8.Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

----00----

Засгийн газрын 2023 .... оны 03 дугаар  
сарын 15.-ны өдрийн 100 дугаар  
тогтоолын 2. дугаар хавсралт

ШТАРХОР 9033010224 5498449

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ  
БАЙГУУЛЛАГЫН ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ЖАГСААЛТ

Нэг.Лавлагаа, тодорхойлолт

№	Төрийн үйлчилгээ	Төрийн байгууллага
1.	Төрсний бүртгэлийн лавлагаа	
2.	Гэрлэсний бүртгэлийн лавлагаа	
3.	Гэрлэсний бүртгэлгүй лавлагаа	
4.	Регистрийн дугаарын лавлагаа	
5.	Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлгүй тухай лавлагаа	
6.	Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийн лавлагаа (анх удаа авсан)	
7.	Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийн лавлагаа (дахин авсан)	
8.	Иргэний үнэмлэхийн лавлагаа	
9.	Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа	
10.	Гэрлэсний бүртгэлгүй лавлагаа (англи)	
11.	Гэрлэсний бүртгэлийн лавлагаа (англи)	
12.	Иргэний үнэмлэхийн лавлагаа (англи)	
13.	Төрсний бүртгэлийн лавлагаа (англи)	
14.	Хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэлтэй эсэх лавлагаа	
15.	Хуулийн этгээдийн хаягийн лавлагаа	
16.	Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн нэрийн тухай лавлагаа	
17.	Хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн тухай лавлагаа	
18.	Хуулийн этгээдийн татан буугдсан эсэх лавлагаа	
19.	Хуулийн этгээдийн бүртгэлгүй тухай лавлагаа	
20.	Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа	
21.	Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа	
22.	Үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа болон шилжүүлсэн тухай лавлагаа	
23.	Үл хөдлөх эд хөрөнгөтэй эсэх лавлагаа	
24.	Дэлгэрэнгүй лавлагаа	
25.	Нэр, хэлбэр өөрчлөгдсөн лавлагаа	
26.	Тамга, тэмдгийн хяналтын дугаарын лавлагаа	
27.	Хуулийн этгээдгүй эсэх лавлагаа	
28.	Хуулийн этгээдтэй эсэх лавлагаа	
29.	Хаягийн лавлагаа	

Улсын  
бүртгэлийн  
ерөнхий газар

30.	Удирдлагын лавлагаа	
31.	Эрхлэх үйл ажиллагааны лавлагаа	
32.	Хувьцаа эзэмшигчийн лавлагаа	
33.	Эцсийн өмчлөгчийн лавлагаа	
34.	Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаа	
35.	Оношилгоо, техникийн хяналтын үзлэгийн лавлагаа	
36.	Автотээврийн хэрэгслийн тorgуулийн мэдээлэл	
37.	Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа (иргэн одоо эзэмшиж байгаа)	
38.	Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа (иргэн өмнө өмчилж байсан)	
39.	Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа (ААН одоо эзэмшиж байгаа)	
40.	Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа (ААН өмнө өмчилж байсан)	
41.	Мэргэшсэн жолоочийн үнэмлэхийн лавлагаа	
42.	Гаалийн байгууллагад өrtэй эсэх тодорхойлолт (иргэн)	
43.	Гаалийн байгууллагад өrtэй эсэх тодорхойлолт (ААН)	
44.	Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн лавлагаа (иргэн)	
45.	Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн лавлагаа (ААН)	
46.	Гаалийн зөрчлийн лавлагаа (иргэн)	
47.	Татварын өрийн үлдэгдлийн лавлагаа	
48.	Байгууллагын татварын тооцоотой эсэх тухай тодорхойлолт	
49.	Татварын тайлангаа тушаасан эсэх тухай лавлагаа	
50.	Тендерийн тодорхойлолт	
51.	Иргэнд олгох тодорхойлолт	
52.	Жолоочийн лавлагаа, мэдээлэл	
53.	Жолоодох эрхийн онoo	
54.	Галт зэвсэг эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа	
55.	Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тодорхойлолт	
56.	Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тодорхойлолт (англи)	
57.	Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт	
58.	Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тодорхойлолт	
59.	Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт	
60.	Иргэн болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан тодорхойлолт	
61.	Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт (иргэн)	
62.	Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт (иргэн) англи	
63.	Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх	

“Автотээврийн  
үндэсний төв”  
ТӨҮГ

Гаалийн  
ерөнхий газар

Татварын  
ерөнхий газар

Цагдаагийн  
ерөнхий газар

Шүүхийн  
шийдвэр  
гүйцэтгэх  
ерөнхий газар

	тодорхойлолт (ААН)	
64.	Суллагдсан тухай тодорхойлолт	
65.	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт	
66.	Иргэн (даатгуулагчид) нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт	
67.	Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт	
68.	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа	
69.	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт (англи)	
70.	Өндөр насны тэтгэвэр тогтоолтын хуудас	
71.	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас	
72.	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас	
73.	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэний тодорхойлолт	
74.	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай өрхийн тодорхойлолт (нийслэл)	
75.	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай өрхийн тодорхойлолт (орон нутаг)	
76.	Бүрэн дунд боловсролын гэрчилгээний лавлагаа	
77.	Суурь боловсролын гэрчилгээний лавлагаа	
78.	Дээд боловсролын сургалтын байгууллагын дипломын тодорхойлолт	
79.	Элсэлтийн ерөнхий шалгалтын лавлагаа	
80.	Газрын кадастрын нэгж талбарын тодорхойлолт	
81.	Газар эзэмших эрхийн лавлагаа	
82.	Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн шүүхийн шийдвэртэй эсэх лавлагаа	
83.	Кадастрын зураг хэвлэж авах	
84.	Газрын төлбөр тооцоо нийлсэн акт	
85.	Хүн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээний лавлагаа	
86.	Нэгж талбарын дуудлага худалдааны анхны үнийн лавлагаа	
87.	Нэгж талбарын суурь үнэлгээний лавлагаа	
88.	Газар эзэмших эрхийн гэрчилгээний лавлагаа	
89.	Вакцины гэрчилгээ	
90.	Олон улсын аяллын эрүүл мэндийн гэрчилгээ- International Travel Health Certificate	
91.	Олон улсын аяллын эрүүл мэндийн гэрчилгээ- International Travel Health Certificate (албан болон дипломат паспортоор)	
92.	Олон улсын аяллын эрүүл мэндийн гэрчилгээ- International Travel Health Certificate (гадаад иргэнд)	
93.	Эмнэлгийн магадалгаа	
94.	Шинжилгээний хариу	
95.	Цусны бүлгийн мэдээлэл	
96.	Ковид-19 шинжилгээний хариу	

97.	Зээлийн мэдээллийн лавлагаа	Монголбанк
98.	Консулын баталгаажуулалт олгосон эсэх лавлагаа	
99.	Дипломат албанд ажилласан байдлын лавлагаа	
100.	Цалингийн тодорхойлолт	Гадаад харилцааны яам
101.	Архивын лавлагаа (Гадаад харилцааны төв архивд холбогдох баримт байхгүй тухай)	
102.	Монгол Улсад ашиглахыг зөвшөөрсөн, Хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн загварын хэмжих хэрэгслийн лавлагаа	
103.	Хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн, хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, сууринуулах, засварлах үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын лавлагаа	Стандарт, хэмжил зүйн газар
104.	Хэмжил зүйн үйл ажиллагааны чадавхаа үнэлүүлсэн Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын лавлагаа	
105.	Хүүхдийн мөнгөнд хамрагдах эсэхийг шалгах	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
106.	Хүүхдийн мөнгөний оноо бодуулах хүсэлт	

## Хоёр.Нэг шатлалт үйлчилгээ

№	Төрийн үйлчилгээ	Төрийн байгууллага
107.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	
108.	Суутгагчийн хуулийн этгээдэд олгосон орлогоос суутгасан татвар	
109.	Дотоодын бараа, үйлчилгээний суутгасан НӨАТ	
110.	Оршин суугч бус этгээдээс суутгасан НӨАТ	
111.	Дотоодын архины онцгой албан татвар	
112.	Дотоодын пивоны онцгой албан татвар	
113.	Дотоодын дарсны онцгой албан татвар	
114.	Дотоодын тамхины онцгой албан татвар	
115.	Дотоодын спиртийн онцгой албан татвар	
116.	Дотоодын шимиийн архины онцгой албан татвар	
117.	Улсын тэмдэгтийн хураамж	
118.	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	
119.	Өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр	
120.	Үүсмэл ордын нөөц ашигласны төлбөр	
121.	Стратегийн ач холбогдол бүхий ордын АМНАТ-ын тусгай төлбөр	
122.	Суутгасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	
123.	Арилжааны банкны суутгасан АМНАТ	
124.	Автын агаарын бохирдлын төлбөр	
125.	Нүүрсний агаарын бохирдлын төлбөр	
126.	Органик уусгагчийн агаарын бохирдлын төлбөр	
127.	Томоохон эх үүсвэрийн агаарын бохирдлын төлбөр	
128.	Ус бохирдуулсны төлбөр	
129.	Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар	
130.	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	

Татварын  
ерөнхий газар

131.	Газрын үл хөдлөх хөрөнгийн албан татвар	
132.	Газрын төлбөр	
133.	Нийслэл хотын албан татвар	
134.	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласны усны төлбөр	
135.	Зам ашигласны төлбөр	
136.	Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн татвар	
137.	Хувь хүний орлогын албан татвар	
138.	Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар	
139.	Иргэний үл хөдлөх, эд хөрөнгө борлуулсны албан татвар	
140.	Галт зэвсгийн албан татвар	
141.	Ойн нөөц ашигласны төлбөр	
142.	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	
143.	Байгалийн ургамал нөөц ашигласны төлбөр	
144.	Ахуйн хэрэглээний ус, рашаан ашигласны төлбөр	
145.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	
146.	Хог хаягдал үйлчилгээний хураамж	
147.	Татварын торгууль	
148.	Татварын алданги	
149.	Газар эзэмших, ашиглах эрх борлуулсны албан татвар	
150.	Авто тээврийн хэрэгсэл болон жолоочийн торгуулийн төлбөр төлөх	
151.	Татвар төлөгчийг бүртгэх	
152.	Татвар төлөгчид тоон гарын үсэг олгох	
153.	Лавлагаа, тодорхойлолт гаргаж өгөх	
154.	Татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр олгох	
155.	E-Tax.mta.mn цахим татварын системд нэвтрэх нууц үг олгох	
156.	E-Tax.mta.mn цахим татварын системд нэвтрэх нууц үг дахин олгох	
157.	НӨАТ (и баримт) нэвтрэх нууц үг солих, зөвлөгөө мэдээллээр хангах	
158.	Төлбөрийн даалгавар, нэхэмжлэх үүсгэх	
159.	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлт	
160.	Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт	
161.	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх оролцоо төсөл	
162.	Нийслэлийн цэцэрлэгт хамрагдах хүсэлт	Боловсрол, шинжлэх ухааны яам
163.	Төрийн өмчийн ерөнхий боловсролын нэгдүгээр ангийн элсэлтийн бүртгэл	
164.	Эмнэлэгт цаг захиалах	Эрүүл мэндийн яам
165.	Урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг	
166.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээнд иргэдийн санал асуулга	Орон нутгийн хөгжлийн сан
167.	Хот хоорондын нийтийн тээврийн автобус хаана яваа	"Автотээврийн

	мэдээллийг ойролцоо байршилаар нь мэдээлэх	үндэсний төв" ТӨҮГ
168.	Хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслээр зорчих тасалбар захиалах	
169.	Газар эзэмших, ашиглах эрхийг барьцаанд бүртгэлгүй лавлагаа авах	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
170.	Газрын кадастрын зургаар үйлчлэх	
171.	Нийслэлийн нутаг дэвсгэрт газар өмчлөөгүй тухай тодорхойлолт гаргаж өгөх	
172.	Газрын төлбөрийн лавлагаа буюу нэхэмжлэл бичиж өгөх	
173.	Газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт гаргах	
174.	Газар эзэмших, ашиглах эрх олгосон захирамжийн лавлагаа олгох	
175.	Газрын төлбөр төлөх	
176.	Өөрийн газрын дэлгэрэнгүй мэдээлэл авах	
177.	Газрын байршлын кадастрын зургийн үнэ төлөх	
178.	Захирамжийн хуулбар олгох	
179.	Бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй танилцах, мэдээлэл авах	
180.	Бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд санал өгөх	
181.	Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах	Нийгмийн даатгалын ерөнхий газар
182.	Улсын чанартай авто зам ашигласны төлбөр төлөх	“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ
183.	Улсын чанартай авто зам ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөх хүсэлт гаргах	
184.	Усан замын тээврийн хэрэгслийн тоо бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийх	“Монгол Улсын далайн захиргаа” ТӨҮГ
185.	Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэлээс хасуулах үйлчилгээ	
186.	Төмөр замын тээврийн зорчигчийн тасалбар захиалах	“Улаанбаатар төмөр зам” ХНН
187.	Иргэний нисэхийн зорчигчийн тасалбар захиалах	Иргэний нисэхийн ерөнхий газар
188.	Хорихын чөлөө олгох өгөх тухай хүсэлт гаргаж өгөх	Дүүргийн Засаг даргын Тамгын газар
189.	Ахмадын түрээсийн орон сууцанд хамрагдах хүсэлттэй иргэдийн жагсаалтад бүртгэх	
190.	Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдыг (хагас өнчин суралцагч, малчин өрхийн суралцагч, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой) сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамруулах	
191.	Монгол Улсын их, дээд сургуулиудад (бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан) суралцагчдад сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох	
192.	Цэргийн үүрэгтний үнэмлэх олгох	
193.	Цэргийн насны иргэдийн шилжилт хөдөлгөөний	

	бүртгэл хийх	
194.	Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр дүйцүүлэн хаасан иргэдэд бичилт хийх	
195.	Цэргийн жинхэнэ албанад татагдсан иргэдийн ар гэрт халамжийн үйлчилгээ үзүүлэх	
196.	Тохижилт үйлчилгээний компанитай хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэх гэрээ байгуулах	
197.	Газар эзэмшигчийн кадастр авто замын трасст орсон эсэх тодруулга гаргах	Нийслэлийн Замын хөгжлийн газар
198.	Зам барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох	Нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төв
199.	Тээврийн хэрэгслийг зориулалтын авто машинаар зөөж, шилжүүлэх үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулах	Нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төв
200.	Орчны хөдөлгөөнт хэмжилт хийх	
201.	Усан халаалтын зуухнуудад хаягдал утааны хэмжилт хийх	Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар
202.	Авто тээврийн хэрэгслийн утааны хийн хэмжилт хийх	
203.	Хүн, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн сайжруулсан хатуу тулшний хаягдал утааны хэмжилт хийх	
204.	Орон сууцны зориулалт өөрчилсөнтэй холбоотой лавлагаа олгох	
205.	Шилжилт хөдөлгөөний холбогдолтой лавлагаа олгох	Нийслэлийн Архивын газар
206.	Акт, дүгнэлтийн лавлагаа олгох	
207.	Цалингийн лавлагаа олгох	
208.	Худалдан авах ажиллагааны лавлагаа	
209.	Төрийн архивд баримт хадгалагдаагүй тодорхойлолт	
210.	Ойн мэргэжлийн байгууллагын эрх олгох, дүгнэлт олгох	
211.	Байгалийн ургамлын мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, дүгнэлт гаргах	
212.	Ан амьтны мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, дүгнэлт гаргах	Нийслэлийн Байгаль орчны газар
213.	Газрын хэвлийн мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, дүгнэлт олгох	
214.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын эрх олгох	
215.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын эрх олгох	
216.	Анги алгасан суралцуулах эсэхийг шийдвэрлэх	Нийслэлийн Боловсролын газар
217.	Оюутны цахим төлбөрийн карт олгох, цэнэглэх	
218.	Өмчлөлийн шийдвэр тараалт	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
219.	Газрын зөрчлийн мэдээлэл илгээх, хүлээн авах	
220.	Гэр хорооллын дахин төлөвлөлтөд хамрагдаж байгаа тухай тодорхойлолт олгох	Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газар
221.	Хэрэглэгчдийн хүсэлтийн дагуу статистик тоон	Нийслэлийн

	мэдээлэл бэлтгэх	Статистикийн газар
222.	Нийслэлийн гудамж замын хөдөлгөөнд ачааны авто машиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах түр зөвшөөрөл олгох	Нийслэлийн Тээврийн үйлчилгээний газар
223.	Мэдээлэл холбооны шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлцөх үйлчилгээ	
224.	Цахилгаан хангамжийн шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлцөх үйлчилгээ	
225.	Усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлцөх үйлчилгээ	
226.	Дулаан хангамжийн шугам сүлжээний трасс зөвшилцөх, зөвшөөрөлцөх үйлчилгээ	
227.	Инженерийн бэлтгэл арга хэмжээ (үерийн далан суваг, хөрсний ус)-ний трасс зөвшилцөх, зөвшөөрөлцөх үйлчилгээ	
228.	Гадна зар сурталчилгааны байгууламжийн загвар зураг батлах	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар
229.	Барилга, байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаврын схем зургийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх хүсэлт	
230.	Улсын нийслэлд хөшөө, дурсгалын самбар байршуулах хүсэлтийг шийдвэрлэх	
231.	Гудамж талбайд нэр өгөх, нэрэмжит болгох	
232.	Нийтийн эдэлбэр газарт авто зогсоол төлөвлөх, байгуулах хүсэлтийг шийдвэрлэх	
233.	Нийтийн эдэлбэрийн газрыг хүн, хуулийн этгээдийн хөрөнгөөр тохижуулах, ашиглах, хамгаалах хүсэлтийг шийдвэрлэх	
234.	Барилгын ажил өхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох	
235.	Барилга байгууламжийн эх загвар зураг батлах	
236.	Гадна тохижилтын ажлын загвар зураг батлах	
237.	Сүүн бүтээгдэхүүнээр нэrsэн шимиин архины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох	Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар
238.	Орон сууцны 00 тоотын эрхийн бичиг олгох	
239.	Орон сууцны 00 тоотын эрхийн бичиг үрэгдүүлсэн тохиолдолд дахин олгох	
240.	Нэр шилжүүлсэн "0" тоотын эрхийн бичиг олгох	
241.	Орон сууцны 00 тоотын эзэмшигч нас барсан тохиолдолд шилжүүлэх	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
242.	Зар сурталчилгааны самбар байршуулах зөвшөөрөл шинээр олгох	
243.	Зар сурталчилгааны самбар байршуулах зөвшөөрөл сунгах	
244.	Холболтын гэрээ хийх	
245.	Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлцуулах аж ахуйн гэрээ хийх	"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ
246.	Бохир ус тээвэрлэн зөөвөрлөх аж ахуйн гэрээ хийх	

247.	Барилгын түр усны зөвшөөрөл олгох	
248.	Үндны ус, бохир усанд лабораторийн шинжилгээ хийх	
249.	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд зөөврөөр ус хүргэх үйлчилгээний гэрээ байгуулах	
250.	Огтолгоо хийх	

Гурав.Олон шатлалт үйлчилгээ

№	Төрийн үйлчилгээ	Төрийн байгууллага
251.	Гэрлэсний гэрчилгээ дахин авах	
252.	Гадаад паспорт дахин захиалах	
253.	Иргэний үнэмлэх дахин авах	
254.	Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл	
255.	Нас барсны бүртгэлийн хүсэлт	
256.	Ургийн овог, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэлийн хүсэлт	
257.	Хүйс өөрчлөгдсөний бүртгэлийн хүсэлт	
258.	Төрсний бүртгэл	
259.	Төрсний гэрчилгээ дахин авах	
260.	Эцэг (эх) тогтоосны бүртгэл	
261.	Үрчилсний бүртгэлийн хүсэлт	
262.	Аймгаас аймагт шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэх	
263.	Аймгаас нийслэлд шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэх	
264.	Баг дотроо шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэх	
265.	Баг хооронд шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэх	
266.	Дүүрэг хооронд шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэх	
267.	Нийслэлээс аймагт шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэх	
268.	Сум хооронд шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэх	
269.	Хороон дотроо шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэх	
270.	Хорооноос хороонд шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэх	
271.	Гүйцэтгэх удирдлага өөрчлөх (гүйцэтгэх захирал, дарга, тэргүүн)	
272.	Салбар төлөөлөгчийн газар шинээр бүртгэх	
273.	Улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгох	
274.	Хуулийн этгээдийн нэр өөрчлөх	
275.	Хуулийн этгээдийн хаяг өөрчлөх	
276.	Хуулийн этгээдийн цахим гэрчилгээ	
277.	Үйл ажиллагааны чиглэл өөрчлөх (нэмэх, хасах)	
278.	Усан замын тээврийн хэрэгсэл, агаарын хөлгийн санхүүгийн түрээс (лизинг)-ийн гэрээний эрхийн бүртгэл	
279.	Хуулийн этгээдийн оноосон нэр авах	
280.	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	
281.	Холбоо, сан	

Улсын  
бүртгэлийн  
ерөнхий газар

282.	Нөхөрлөл
283.	Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар
284.	Сервитутын бүртгэл
285.	Узуфруктын бүртгэл
286.	Батлан даалтын гэрээг улсын бүртгэлд бүртгүүлэх
287.	Бусдын газар дээр барилга байгууламж барих эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт
288.	Түрээсийн бүртгэл
289.	Төрөөс үнэгүй хувьчилсан газрын өмчлөх эрхийг баталгаажуулах
290.	Төрөөс үнэгүй хувьчилсан орон сууц өмчлөх эрхийг баталгаажуулах
291.	Эд хөрөнгө өмчлөх эрхийн худалдах, худалдан авах гэрээг улсын бүртгэлд бүртгэх
292.	Регистрийн дугаар өөрчлөгдсөнийг бүртгүүлэх хүсэлт
293.	Нөхөн бүртгэл хийлгэх
294.	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч өөрчлөх
295.	Хуулийн этгээд татан буулгах тухай мэдэгдэх
296.	Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл (төрөөс худалдаж авсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх)
297.	Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл (бэлэглэх гэрээ)
298.	Хуулийн этгээдийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулагдсаныг бүртгэх
299.	Хуулийн этгээдийг нийлүүлэх замаар өөрчлөн байгуулагдсаныг бүртгэх
300.	Хуулийн этгээдийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулагдсаныг бүртгэх
301.	Хуулийн этгээдийг хуваах замаар өөрчлөн байгуулагдсаныг бүртгэх
302.	Хуулийн этгээдийг “Хэлбэр өөрчлөх замаар” өөрчлөн байгуулагдсаныг бүртгүүлэх
303.	Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл (газраас бусад YХЭХ-ийг анх удаа бүртгүүлэх)
304.	Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл (арилжих гэрээ)
305.	Эцэг (эх) тогтоосны бүртгэлийн лавлагаа
306.	Гэрлэлтийг бүртгэх
307.	Гэрлэлт цуцлуулсныг бүртгэх
308.	Төрсний гэрчилгээний дахин олголтыг бүртгэх
309.	Иргэний цахим үнэмлэх авч байгаагүй тухай лавлагаа олгох
310.	Гэрлэлт цуцалсны гэрчилгээ дахин олгох
311.	Хэдэн хүүхэд төрүүлсэн тухай лавлагаа
312.	Худалдах, худалдан авах гэрээг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх
313.	Өв залгамжлах эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх
314.	Өмчлөгч өөрт ногдох хэсгээ бэлэглэх, худалдах гэрээг улсын бүртгэлд бүртгэх

315.	Өмчлөгчийн үүсгэн байгуулсан хуулийн этгээдээс иргэнд, иргэнээс үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн өмчлөлд өмчлөх эрх шилжсэнийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх
316.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах (хаяг өөрчлөгдөх)
317.	Эд хөрөнгийн барьцаалбартай барьцааны гэрээг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх
318.	Эд хөрөнгийн барьцаалбаргүй барьцааны гэрээг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх
319.	Эд хөрөнгийн барьцаалбартай барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах бүртгэл хийх
320.	Эд хөрөнгийн барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах бүртгэл хийх
321.	Барьцааны эрх дуусгавар болсныг эрхийн бүртгэлд бүртгэх
322.	Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааг эрхийн улсын бүртгэлд бүртгэх
323.	Батлан даалтын гэрээг эрхийн улсын бүртгэлд бүртгэх
324.	Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг эрхийн улсын бүртгэлд бүртгэх
325.	Санхүүгийн түрээс (лизинг)-ийн гэрээг эрхийн улсын бүртгэлд бүртгэх
326.	Барьцааны гэрээнээс бусад гэрээ дуусгавар болсныг эрхийн улсын бүртгэлд бүртгэх
327.	Барьцааны гэрээнээс бусад гэрээнд өөрчлөлт орсныг эрхийн улсын бүртгэлд бүртгэх
328.	Эд хөрөнгийн лавлагаа олгох (өмчтэй эсэх)
329.	Эд хөрөнгийн лавлагаа олгох (барьцаатай эсэх)
330.	Архивын баримтаас хуулбар олгох
331.	Хуулийн этгээдийг улсын бүтгэлд бүртгэх
332.	Шашны байгууллагыг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэх
333.	Хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд тусгах
334.	Хуулийн этгээдийн үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгох
335.	Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулснаар шинээр гэрчилгээ олгох
336.	Өвлөх эрхийн гэрчилгээгээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэх
337.	Шилжиж ирсэн хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх
338.	Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт орсныг улсын бүртгэлд бүртгэх
339.	Шашны байгууллагын мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх
340.	Шилжүүлсэн хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх
341.	Шашны байгууллагын гэрчилгээний хугацаа сунгах

342.	Компанийг бүртгэлээс хасаж татан буулгах
343.	Тамга, тэмдгийн хяналтын дугаарын бүртгэл хийх
344.	Тамга, тэмдэг хурааж авах
345.	Тамга, тэмдгийн лавлагаа олгох
346.	Нас барсны бүртгэлийн баримтын лавлагаа
347.	Гэрлэлт дуусгавар болсны бүртгэлийн лавлагаа
348.	Регистрийн дугаар өөрчилсөн лавлагаа
349.	Овог, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэлийн лавлагаа
350.	Овог, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэлийн лавлагаа (хүүхдийн)
351.	Хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулах
352.	Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хугацаа сунгуулах
353.	Хуулийн этгээдийн нэрийн өөрчлөлт баталгаажуулах
354.	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага
355.	Хадгаламж зээлийн хоршоо
356.	Шашны байгууллага
357.	Нийтийн эрх зүйн хуулийн этгээд
358.	Төрийн байгууллага, албан газар
359.	Улсын төсөвт үйлдвэрийн газар
360.	Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
361.	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
362.	Олон улсын гэрээ, хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газар
363.	Гадаадын хуулийн этгээд (компани, нөхөрлөл)-ийн төлөөлөгчийн газар
364.	Гүйцэтгэх удирдлага өөрчлөлт (гүйцэтгэх захирал, дарга, тэргүүн)
365.	Хуулийн этгээдийн нэр өөрчлөлт
366.	Хуулийн этгээдийн хаяг өөрчлөлт
367.	Үйл ажиллагааны чиглэл өөрчлөлт
368.	Улсын бүртгэлийн гэрчилгээ дахин авах
369.	Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар (шинэ, өөрчлөлт)
370.	Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч (гишүүн) өөрчлөлт
371.	Хөрөнгө өөрчлөлт (компанийн хувьд хувь нийлүүлсэн хөрөнгө)
372.	Хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах хугацааг сунгуулах
373.	Хуулийн этгээдийн дүрэм (гэрээ) өөрчлөлт
374.	Эрх барих этгээдийн өөрчлөлт (УЗ, ТУЗ)
375.	Эцсийн өмчлөгчийн өөрчлөлт
376.	Шинэчилсэн бүртгэлд хамрагдаж улсын бүртгэлийн гэрчилгээ солиулах
377.	Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын мэдээлэлд оруулсан өөрчлөлт

378.	Хуулийн этгээдийг татан буулгасныг улсын бүртгэлд бүртгүүлэх	
379.	Баримт бичгийн хуулбар авах	
380.	Хуулийн этгээдийг татан татан буулгах тухай мэдэгдэх	
381.	Хуулийн этгээдийг татан буулгасныг бүртгүүлэх	
382.	Тамга, тэмдэг хураалгаж шинээр хяналтын дугаар авах	
383.	Нас барсны бүртгэлийн архивын лавлагаа	
384.	Авто тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулах	
385.	Авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ нөхөн олгох хүсэлт	
386.	Авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ солих үйлчилгээ	
387.	Мэргэшсэн жолоочийн үнэмлэх нөхөн олгох хүсэлт хүлээн авах	
388.	Жуулчин тээврийн үйлчилгээ	
389.	Тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн	
390.	Тээврийн хэрэгслийн с зөвшөөрөл	
391.	Импортын тээврийн хэрэгслийн бүртгэл	
392.	Жолооны үнэмлэх солих, нөхөн олгох	
393.	Монгол Улсын олон улсын жолоодох эрхийн үнэмлэх захиалах (1 жил)	
394.	Монгол Улсын олон улсын жолоодох эрхийн үнэмлэх захиалах (2 жил)	
395.	Монгол Улсын олон улсын жолоодох эрхийн үнэмлэх захиалах (3 жил)	
396.	Дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулсан талаар цагдаагийн байгууллагын санал	
397.	Янгиллын визийн зөвшөөрөл хүсэх	
398.	Гадаадын хүн, уригчийн зөрчил гаргасан эсэх тухай тодорхойлолт	
399.	Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй эсэх тухай тодорхойлолт	
400.	Монгол Улсын харьяатаас гарсан эсэх тухай тодорхойлолт	
401.	Монгол Улсын харьят болсон тодорхойлолт	
402.	Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон тухай тодорхойлолт	
403.	Гадаадын иргэний бүртгэл	
404.	Оршин суух зөвшөөрөлтэй эсэх тухай лавлагаа	
405.	Хасалт хийсэн тухай тодорхойлолт	
406.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргах	
407.	Химийн хорт болон аюултай бодис ашиглах зөвшөөрөл	
408.	Химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах зөвшөөрөл (1 - 10 тонн)	
409.	Химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах зөвшөөрөл (1 тонн)	

410.	Химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах зөвшөөрөл (10 - 50 тонн)	
411.	Химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах зөвшөөрөл (100 - 150 тонн)	
412.	Химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах зөвшөөрөл (150 - 200 тонн)	
413.	Химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах зөвшөөрөл (200 тонн дээш)	
414.	Химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах зөвшөөрөл (50 - 100 тонн)	
415.	Химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах, худалдах зөвшөөрөл (1 - 10 тонн)	
